




Баян хүн Лазар хоёрын тухай өгүүллэг III

Хам сэдвийг нь судлахад: Фарисайчуудад ярьсан сургаалт зүйрлэл

Үхлийн дараах сэдвийн талаар янз бүрийн зөрчилтэй ойлголтууд итгэгч нар, пасторууд, теологчдын дунд элбэг байдаг нь маш эмгэнэлтэй. Ингэж төөрөх нь шилжсэн утгаар ойлгох ёстой зүйлийг шууд утгаар, шууд утгаар ойлгох ёстойг шилжсэн утгаар хөнгөн хуумгай хүлээж авдгийн үр дагавар юм. Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэгийг хүмүүс ихэвчлэн тэр урвуу байдлаар ойлгодог. Гэвч тус өгүүллэг түүхэн явдал байх боломжгүйг бид өмнөх хоёр нийтлэлээс харсан. Харин үхэл ба Үхэгсдийн орон тухай олон ишлэлийг шууд утгаар ойлгох нь утга учиртай.

Энэ нийтлэлд бид тус өгүүллэгийн учрыг ойлгох гэж юуны өмнө хам сэдвийг нь буюу эргэн тойронд нь буй “хүрээлэл”-ийг нь судлах болно.

Буруу сургаалыг хүмүүс Библийн ишлэлээр нотлодог бол анх сонсоход үнэмшилтэй юм шиг санагдана. Гэвч гаж сургаалыг батлахаар татсан ишлэлийг ихэвчлэн хам сэдвээс нь гарган салж, өөр утгатай болгосон байдаг. Тиймээс ч *“Библийн ямар ч хэсгийг зөв ойлгохын тулд хам сэдэвтэй нь үзэх ёстой”* гэсэн чухал зарчим бий.





Үүний тулд бид судалж буй хэсгийнхээ хам сэдвийн талаар асуулт асуух хэрэгтэй. Тухайлбал:

-Уг хэсэг ямар орчин тойронд, ямар явдлын дунд шигтсэн вэ?

-Хэлэгдэж буй үгийг хэн, ямар нөхцөл байдлаар, хэнд ярьсан бэ?

-Ямар нэгэн маргаан зөрчилдөөн дунд гардаг уу?

-Тухайн хэсгийн оргил хэсэг, гол санаа нь юу вэ?

-Анхны сонсогчид нь үүнийг хэрхэн ойлгох байсан бэ?

-Энэ хэсгийг Библид оруулсны зорилго чухам юу вэ?

-Библийн ерөнхий сургаалд хэрхэн багтдаг вэ?

Ялангуяа шууд ойлгоход хэцүү хэсэгт ийн асуух нь чухал байдаг. Харамсалтай нь, ялангуяа баян хүн, ядуу Лазарын тухай заахдаа хам сэдвийг нь огт авч үздэггүй байх нь элбэг.

Нэгэн сургаалт зүйрлэлийг бүрдүүлсэн таван үлгэр

*Библийн ямар ч
хэсгийг зөв
ойлгохын тулд
хам сэдэвтэй нь
үзэх ёстой.*

Тус өгүүллэг Лук 16:19-31-т гардаг. Тэрнээс өмнө Лук юу гэж бичсэнийг харцгаая. Лукын өгүүлснээр Есүс маш олон гайхамшиг хийж, Ертөнцийн Эзэний илгээхээр

амалсан Тосолсон Нэгэн мөн болохоо ахин дахин баталсан боловч иудейчүүдийн удирдлага болох ахлах тахилч нар ба фарисайчууд Түүнийг хүлээж авсангүй. Тэд Есүсийн хэлсэн нэг ч үгэнд итгэхээс татгалзаж, Түүнд дургүйцэн, тэр ч бүү хэл Түүгээр доог тохуу хийдэг байсан (Лук 16:14). Фарисайчуудын нэгэн удирдагч Есүсийг “нягтлан ажиглах” гэж иудейчүүдийн шаббат гэдэг амралтын өдөр гэртээ хоол идэхээр урьсан (Лук 14:1). Тэнд байхдаа Есүс



усан хавантай хүнийг эдгээнгээ бусдыг аврах нь хэр чухал байх (14:2-5), даруу байх (14:8-11), ядуу, тахир дутуу, хазгар доголон, сохор хүмүүсийг чухалд үзэх тухай тэдэнд ярьсан (14:13, 21).

Тэгээд гадаа нь цугласан олонд үргэлжлүүлэн сургаал заахад албан татвар хураагч, “гэмт хүмүүс” Түүнийг сонсох гэж дэргэд нь ирсэн (14:25; 15:1). Тэднийг Есүс дуртайяа хүлээж авсанд фарисайчууд дургүйцэн “гэмт хүмүүс”-тэй нөхөрлөж байгаагийнх нь төлөө шүүмжилдэг (15:2).

Хариуд нь Есүс тэднийг зэмлэж, буруу ойлголтыг нь засах гэж мөн “нэгэн” сургаалт зүйрлэл айлдав” (Лук 15:3). Үүнд төөрсөн хонины тухай сургаалт үлгэрээс гадна гээсэн зоос, тэнэмэл хүүгийн тухай өгүүлэл багтна. Түүгээр ч зогсохгүй, 16-р бүлэгт зальт даамлын тухай өгүүллэг ч гэсэн сургаалт зүйрлэл болох тал дээр итгэгчид бүгд санаа нэг байх. Энэ дөрвөн сургаалт үлгэрийн дараа Есүс баян хүн, ядуу Лазар хоёрын тухай ярьсан.

“Хоёр хүүтэй нэг хүн байжээ...” (15:11) гэж эхэлдэг 3-р сургаалт зүйрлэлийг сүүлчийн хоёр өгүүллийн эхлэлтэй харьцуулбал: “Нэгэн баян хүн няравтай байжээ...” (16:1); “Нэгэн баян хүн байжээ...” (16:19).

Бүгд ийнхүү яг адилхан маягаар эхэлдэг нь сүүлчийнх нь бусадтай адилхан сургаалт үлгэр мөн болохыг баталж

№	Багц сургаалт зүйрлэл	ишлэл
1	төөрсөн хонь	Лук 15:3-7
2	гээсэн зоос	Лук 15:8-10
3	тэнэмэл хүү	Лук 15:11
4	зальт даамал	Лук 16:1-13
5	баян хүн, ядуу Лазар хоёр	Лук 16:19-31

байна. Энэ бүхнээс харахад, Есүсийн ярьсан таван өгүүлэл бол нэг л сургаалт зүйрлэлийн таван цуврал хэсэг болох нь ойлгогдож байна.



Есүсийн ярьсан бүх сургаалт зүйрлэл Түүний тунхагладаг Хаант улсын тухай болой. Иймд энэ таван өгүүллэл Хаант улсын чухал нэгэн үнэнийг алмазны гялтганах талст шиг хэд хэдэн талаас харуулсан бөгөөд бүгд нийлээд бүхэл бүтэн нэгэн зүйрлэлийг бүрдүүлдэг.



Жич: Лук бичсэн номоо бүлэг, ишлэлээр хуваагаагүйг бид санах хэрэгтэй. Stephen Langton хэмээх англи сүмийн нэгэн удирдагч 1227 оны орчим буюу Чингис Хааны үед л Библийг анх бүлэг болгон хуваасан байна. Ишлэлээр хуваасан нь бүр дараа нь болсон явдал («Хуучин Гэрээ»-г еврей багш Натан 1448 онд ишлэлээр хуваасан бол «Шинэ

Гэрээ»-г Robert Estienne 1555 онд тэгэж хуваажээ). Дээр нь орчин үед олон орчуулгын хэвлэл энд тэнд нь янз бүрийн гарчиг нэмсэн байна. Ийн хуваасан нь ямар нэгэн ишлэлийг хурдан олоход их тустай ч гэсэн, хамт ойлгогдох ёстой хэсгийг хэсэгчлэн тасалсны улмаас Библийг зөв ойлгоход саад болж мэднэ. Нэг л яриагаар бүрдсэн «Лук» 15-16 бол үүний нэг жишээ юм. Иймээс Ертөнцийн Эзэний Үгийн утгыг судлахдаа бид хүний оруулсан бүлэг, ишлэлийн хуваарилалтанд ач холбогдол өгөх хэрэггүй.

Сургаалт зүйрлэлээр ярих арга зүй ба зорилго

Сургаалт зүйрлэлээр аливааг илэрхийлэх нь эртний еврейчүүдийн дунд түгээмэл байсан. «Хуучин Гэрээ»-ний хэдэн жишээ: Шүүгдчид 9:7-15, 2 Самуел 12:1-4,



14:1, Хаадын Дэд 14:9, Езекиел 24:3-5. Паул ч зүйрлэл хэрэглэдэг байсан (жишээ нь Ром 11:16-24).

Хэтрүүлэл бол сургаалт зүйрлэлийн нэгэн шинж тэмдэг юм.

Хүний ширээнээс унасан үйрмэгээр амь зогоох, галд шатаж буй хүний хэлийг ганц



дусал усаар сэрүүцүүлнэ гэдэг бол хэтрүүлэл болох нь ойлгомжтой. Паулын иш татсан нэг үг галт шийтгэлтэй холбоотой ч хэн ч шууд утгаар нь ойлгодоггүй. Үүнд: **“Хэрэв дайсан чинь өлссөн бол түүнийг хоолло. Хэрэв тэр цангасан бол түүнд уух юм өг. Учир нь чи ингэснээрээ түүний толгой дээр галтай нүүрс овоолж байгаа хэрэг”** (Ром 12:20, Сургаалт үгс 25:22). Бодит галыг энд хэлээгүй, харин хүнийг ичээж, зөв замд ороход нь өдөөх тухай ярьж байна.

Есүс сургаалт үлгэр, зүйрлэлээр ярьдаг байсан шалтгаан нь сургаалаа тодорхой болгоход оршино хэмээн ихэнх итгэгч боддог. Гэтэл тийм биш! Сургаалт зүйрлэлээр Есүс үнэнийг харин ч далдалдаг байсан (Матай 13:13-15). Тийм ч учраас сургаалт зүйрлэл ихэнх сонсогчдын хувьд ээдрээтэй, толгой эргэмээр, ойлгомжгүй байдаг.

Тухайлбал, үр тарианы тухай сургаалт үлгэрийг нэрлэж болно. Есүс тэр үлгэрийг тайлбарлаагүй байсан бол бид өнөөдөр, зам дээр унасан үрийг түүж иддэг шувууд юуг билэгддэгийг ойлгож авч чадах нь эргэлзээтэй юм (Матай 13:3-8; 18-23).



Сургаалт зүйрлэлийнхээ далд утгыг Есүс зөвхөн дагалдагч нартаа тайлбарладаг байсан. Гэвч Ертөнцийн Эзэний Үгийг амьдралынхаа турш судалсан хэрнээ Түүний Тосолсон Нэгнийг таниагүй, Түүний

төлөвлөгөөг огтхон ч гадарлаагүй, Түүний зүрх сэтгэлээс алс хол байсан фарисайчуудад тайлбарлаагүй. Мохсон сэтгэл бүхий тэд “нүдэн балай, чихэн дүлий” мэт байсны улмаас үзсэн зүйлээ ухаараагүй, сонссон үгээ ойлгоогүй сэтгэл зүрхэндээ ухамсарлаж чадаагүй. Үүний адилаар өнөөдрийн теологич, пасторууд теологийн их сургуульд хичнээн сайн дүнтэй сурлаа ч гэсэн Ертөнцийн Эзэний Үгийг ойлгосон байхын баталгаа байхгүй билээ. Баян хүн, ядуу Лазар хоёрын сургаалт үлгэрт Есүсийн өгсөн тайлбар байхгүй. Яагаад тус өгүүллэг өнөөдөр ч олны дунд буруу ойлгогдоод байгаа нь Есүс үнэнийг зүйрлэлээрээ далдалдаг байсантай шууд холбоотой.

Есүсийн сонсогчид: фарисайчууд

Дагалдагч бус хүмүүст “Тэр сургаалт зүйрлэлгүйгээр ярьсангүй” (Маарх 4:34). Есүс фарисайчуудад ч гэсэн сургаалт үлгэрээр л ярьдаг байснаас харахад баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг ч мөн сургаалт



зүйрлэл болох нь дахин батлагдаж байна. Үнэндээ, Библийн тайлбар бичсэн олон хүн уг өгүүллэгийг сургаалт зүйрлэл болох тал дээр санал нэгддэг. Харин чухам юуг билэгддэг тал дээр янз бүрийн утгын тайлал бий.

Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай сургаалт үлгэрийг чухам ямар утгатай болохыг олж нээхийн тулд эхлээд өмнө нь өрнүүлсэн яриаг илүү сайн шинжиж үзэх хэрэгтэй.

Ертөнцийн Эзэнээс холдсон “гэмт” хүмүүсийг хүлээж авсных нь төлөө Өөрийг нь шүүмжилж байгаа нь ямар утгагүй хэрэг болохыг фарисайчуудад харуулахын тулд Есүс эхний гурван өгүүллэгээ ярьсан.

Фарисайчуудын хувьд хүртэл төөрсөн хониныхоо араас явж, гээгдсэн зоосоо эрж хайн, харьж ирсэн хүүгээ хүлээж авах нь мэдээж хэрэг байлаа. Тэгвэл Их Эзэн тэнэж төөрсөн хүмүүсээ эрж хайх нь ч гэсэн мэдээж хэмээн Есүс тайлбарладаг. Чухам тэр хүмүүст фарисайчууд Ертөнцийн Эзэний хайрыг заах, харуулах ёстой байхад тэднийг харин ч үзэн ядаад, зэвүүцсэн, гадуурхаад зогсохгүй бүр Ертөнцийн Эзэнийг хүндлэх газарт оруулдаггүй байсан. Эдгээр “гэмт хүмүүс” Есүс дээр ирж байгаад дургүйцэж буй фарисайчууд нь Аавынхаа “хөрөнгийг янхнуудтай нийлж цөлмөсөн” дүүгээ эргэж ирсэнд дургүйцэн уурладаг тэнэмэл хүүгийн ах шиг (15:28-30). Ганц “нүгэлтэн” Ертөнцийн Эзэн дээр эргэж ирэхэд тэнгэрт маш их баяр хөөр болдог бол өөрсдийгөө “гэмших шаардлагагүй зөвт хүн” гэж үздэг фарисайчууд Ертөнцийн Эзэнд хэзээ ч тийм баяр хөөрийг авчрахгүйг Есүс тэдэнд сануулдаг (15:7).



Зальт даамлын тухай 4-р сургаалт үлгэрээр дамжин Есүс фарисайчуудын мөнгөнд шуналтайн улмаас Ертөнцийн Эзэний итгэмжлэн даатгасан сүнслэг баялгыг “үрэн таран хийж” байгааг шүүмжилдэг. “Нүгэлтэн” хүмүүсийг

эргээд Ертөнцийн Эзэн дээр авчрахад зүтгээгүй тэд итгэмжит даамал бус болохоо харуулсан. **“Хоёр эзэнд үйлчилдэг зарц байдаггүй. Учир нь тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлана. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцдэг. Та нар Бурханд ба эд баялагт зэрэг үйлчилж чадахгүй...”** (16:13).

Ертөнцийн Эзэн Өөрийн зарц нараа хоёрдмол бус, бүхий л сэтгэлээсээ үйлчлээсэй гэж хүсдэг. Гэвч Түүний яруу алдраас өөр зүйл тэднийг хөдөлгөдөг юм бол энэ нь боломжгүй. Мөнгийг хайрладаг учраас мөнгөнд үйлчилж, мөнгөнөөс зуурдаг хүн тэгвэл Ертөнцийн Эзэнийг үнэн сэтгэлээс хайрлаж чадахгүй, Түүнд үйлчилж чадахгүй, Түүнээс зуурдаггүй, харин ч Түүнийг зэвүүцэн үзэн ядахад хүрнэ гэсэн үг. Энэ бүхнийг сонсоод мөнгөнд дуртай фарисайчууд Есүсийг тохуурхан инээлдэхэд (16:1-14) Есүс үргэлжлүүлэн: **“Та нар бол хүмүүсийн өмнө өөрсдийгөө зөвтгөгчид юм. Гэвч Бурхан та нарын**



зүрхийг мэднэ. Яагаад гэвэл хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы өмнө жигшмээр юмс байдаг” гэж сануулдаг (Лук 16:13+15). Бид бүгд фарисайчуудын адил хүмүүсийн өмнө зөв харагдах хүсэлтэй байдаг. Гэтэл хоёр нүүртэй байхын оронд хүмүүсийн өмнө буруу харагдсан ч Ертөнцийн Эзэний хувьд зөв хүн байх нь хамаагүй дээр.

Эцэст нь Есүс фарисайчуудад баян хүн, ядуу Лазар хоёрын тухай 5-р сургаалт үлгэрээ ярьдаг. Абрахам, Мосе болон эш үзүүлэгч нарыг гол сонсох ёстой хүмүүс гэдэг. Үүнээс ч харахад энэ сургаалт үлгэр еврейчүүдэд зориулсан нь тодорхой. Тийм байхад Мосегийн хуулийг аваагүй бусад үндэстний хүмүүсийн үхлийн дараах нөхцөл байдалтай бид энэ үлгэрийг холбож ойлгох ёсгүй (Ром 2:14; 3:19). Мөн, “дүү нарт чинь Есүс болон Түүний төлөөлөгчид байна” гэж Абрахам хэлээгүй учраас Христийн тухай сайн мэдээнд итгэгч бидэнд ч энэ өгүүллэл шууд зориулагдаагүй нь ойлгомжтой биз ээ.

Вавилоноос гаралтай, фарисайчуудийн ташаа сургаал

«Хуучин гэрээ»-нд байхгүй ч, энэ үлгэрт орсон үг хэллэг, ойлголтыг Есүс Өөрөө зохиогоогүйг бид мэдэх хэрэгтэй. Эдгээр нь тухайн үеийн шашны хам сэдэвт багтжээ. Иудейчүүд МЭӨ 6-р зуунд Вавилонд цөллөгдсөнөөсөө хойш олон зуун жил тэнд амьдарсан. Вавилоны гүрэн мөхсөний дараа Агуу Александр гараад грек соёл иргэншлийн хамт грек хэлээ хаа сайгүй дэлгэрүүлсэн. Иймд «Хуучин Гэрээ»-г МЭӨ 3-р



зуунаас эхлэн грек хэл рүү орчуулах хэрэг гарсан. “Шеуул” хэмээх еврей Үхэгсдийн орон гэдэг үгийг грекээр “Хадес” гэж орчуулсан. Даанч грекчүүд “Хадес”-ийн талаар «Хуучин Гэрээ»-нд зааснаас огт өөр төсөөлөлтэй. Грек домгийн дагуу далавч бүхий Гермес бурхан үхэгсдийн сэтгэлийг Хадес луу дагуулдаг. Тэнд үхэгсдийн сэтгэлүүд гүн ангалаар хуваагдсан сайн, муу хоёр талд нь сүүдэр мэтээр оршдог. Муу хүний сэтгэл галтай гол дотор тарчлан зовж байхад сайн хүнийх жаргадаг гэсэн. Энэ төсөөлөл нэг л танил байгаа биз?



Грекжүүлсэн иудейчүүд грек философич Платоны үхэшгүй сэтгэлийн тухай сургаалыг ч, Үхэгсдийн орны тухай домогт ойлголтыг хүлээж авсан (Dawson, 1943). Харийн шашнаас орж ирсэн үзэл бодлыг өөрийнх болгосон иудейн олон янзын ном, Есүсийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнө гарсан. Тухайлбал, МЭӨ 200 онд орчим бичигдсэн, өнөө үед шинээр алдаршиж буй “Енох” хэмээх иудейн домог бүхий ном бий. Зохиогч нь хөрст дэлхийн цөмд очиж, тэнд Үхэгсдийн орны хоёр хэсэг үзсэн тухайгаа бичдэг. Үхэгсдийн оронтой холбоотой янз бүрийн харийн шашны ойлголтыг иудейчүүд бусад үндэстнээс авч, Их Эзэний сургаалтай хольж хутгасан.





Үүнд: “Абрахамын өвөр”, тэнгэр элч шударга хүнийг тийш аваачих, үхэгсэд хоорондоо ярилцах, Абрахамаас юм гуйхаар хүүхэд илгээх, үхэгсдийн орон хоёр хуваагдсан байх, мөнхийн галаар асдаг там энэ бүх ухагдахуун «Хуучин гэрээ»-нд биш, харин «Талмуд» хэмээх еврей багш нарын уламжлалт номлол бүхий номд бичигдсэн байна. Дахин хэлье, ийм ухагдахуун ч, ойлголтууд ч «Хуучин гэрээ»-ний хаанаас ч олдохгүй, харин ч Их Эзэний Үгэнд харш байдаг.

«Шинэ гэрээ»-ний сургаалыг бид тэгвэл харийн шашины ойлголтоор биш, «Хуучин гэрээ»-ний үндсэн дээр л ойлгох ёстой.

Хүний уламжлалаар Их Эзэний үгийг бүү хүчингүй болго!

Иудейчүүд эдгээр уламжлалаа Их Эзэний үгнээс илүүд үзэн дээдэлдэг нь Есүсийн бухимдлыг ихэд хүргэдэг байсан. **“Та нар уламжлан авсан ёс заншлаараа Бурханы үгийг хүчингүй болгодог”** гэж Есүс тэднийг зэмлэсэн (Маарх 7:13).

Тийм учраас Есүс дагалдагч нараа анхааруулж: **“Фарисай болон садукайчуудын хөрөнгөнөөс сэрэмжил, болгоомжил”** гэхэд тэд удалгүй Түүнийг “талхны хөрөнгөнөөс биш, харин

фарисай болон садукайчуудын сургаалаас болгоомжил гэж айлдсаныг ухаарав” (Матай 16:6,12).





Бид тэгвэл фарисайчуудын заасан, “Абрахамын өвөр” болон “галтай там”-ын тухай сургаалыг өөрийнх болгож, үхлийн тухай Ертөнцийн Эзэний үгийг хүчингүй болгохоос сэрэмжлэх ёстой гэсэн үг. Харин садукайчууд эсрэгээр нь үхэгсэд дахин амилахгүйд итгэдэг байсан (Матай 22:23; Үйлс 23:8). Энэ нь ч гэсэн бидний болгоомжилж явбал таарах буруу сургаал билээ (1 Коринт 15:12-19).



Фарисайчуудын үзлээр хүн Ертөнцийн Эзэний Хуулийг нарийн чанд сахисны төлөө Түүнээс материаллаг ивээл дүүрэн, чинээлэг амьдралыг шагнал болон хүртдэг (Дэд хууль 28:1-14, Левит 18:5) бөгөөд эцэст нь диваажинд орно. Харин ядуурал, өвчин зэргийг тэд Ертөнцийн Эзэний эсрэг гэм үйлдсэний үр дагавар гэж үздэг байв (Дэд хууль 28:15-68).

Энэ нь үнэний хувьтай. Паул ч гэсэн **“Бурхан хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө... Бузар мууг үйлдэгч хүн бүрийн дээр цөхрөл, зовлон байх болно... Харин сайныг үйлдэгч хүн бүрд алдар, хүндэтгэл ба амар тайван нь байх болно”** гэж бичсэн (Ром 2:6-10).



Гэтэл Хуулийн гол шаардлага Ертөнцийн Эзэнийг болон хажууд буй хүнээ хайрлах хайр буюу энэрэл үзүүлэх, шударгаар үйлдэх, даруухан байх гэдгийг фарисайчууд ойлгосонгүй.

(Дэд хууль 6:5; Левит 19:18; Матай 22:36-40; Мика 6:8: “Юу нь сайн гэдгийг хүн чамд айлдсан бус уу? Юу хүсэж байгаагаа чамд ИАВЭ мэдүүлсэн биш үү? Зөв шударгыг үйлд, энэрэл журмыг эрхэмлэ. Өөрийнхөө Бурхантай даруухнаар алх!”)

Фарисайчууд өөрсдийгөө “Мосегийн дагалдагчид” гэж үздэг (Иохан 9:28) хэрнээ **“Бурхан ИАВЭ чинь та нараар сахиулж мөрдүүлэх гэж тушаасан тушаалыг би та нарт бүгдийг хэлж өгсөн. Үүн дээр юуг ч бүү нэм, үүнээс юуг ч бүү хас”** гэсэн Мосегийн үгийг тэд мартсан бололтой (Дэд хууль 4:2).



Тэд Их Эзэний үгэн дээр харийн шашнаас авсан ойлголтуудыг нэмэхийн тулд үхлийн тухай сургаалыг нь хассан жишээтэй.

Улмаар тэд Мосегийн хуулин дээр олон шинэ, дарамттай хууль дүрэм нэмж, үүгээр ард түмнийг эрхшээлдээ оруулчихаад ядуусын нуруун дээр нилээд баяжсан (Матай 23:4; Марк 7:1-13; Лук 20:46-47).

Ядуучуудад өгөөмрөөр туслах ёстойг Мосе тушаасныг тэд мөн умартсан гэсэн үг (Дэд хууль 5:11). **“Ядууг дарлаваас Бүтээгчийг нь басаж буй хэрэг. Үгээгүйг нигүүлсвээс Бүтээгчийг хүндэлж буй хэрэг...**

Ядуг энэрсэн ачлал ИАВЭд өгсөн зээл болно.

Явдал үйлийнх нь хариуг ИАВЭ буцааж төлнө...



Хоосон ядууг орилоход чихээ таглагч нь Хожим өөрөө ориловч хариуг эс авна.”

“Зүдүү доройг халамжлагч нь сайшаалтай яа!

Зүдэрч зовох цагт нь ИАВЭ түүнийг аварна” гэсэн үгийг тэд хэзээ ч уншаагүй мэт (Сургаалт үгс 14:31; 19:17; 21:13; Дуулал 41:1).

Тэдний ардад заасан сургаалын дагуу “тахир дутуу хүмүүс нэг бол өөрсдөө, нэг бол аав ээж нь Ертөнцийн Эзэний эсрэг гэм хийсэн учраас зовлон хүртэх ёстой, хараагдсан хүмүүс ба тамд орвол таарна” гэж үздэг байв (Иохан 9:2,34-с сохор хүний жишээг үзнэ үү).

Фарисайчуудын хуурамч зан

Гэвч Ертөнцийн Эзэний Хуулийг төгс дагаж чадах хүн байдаггүй. Хуурамч зантай, бузар үйлстэй фарисайчууд өөрсдийгөө ч хараагдсан хүмүүс болохоо ухаарсангүй (Дэд хууль 27:26; Ром 3:20-23-ын дагуу). Өөрсдөө



“сохруудыг удирддаг сохрууд” болох тэд (Матай 15:14) харин ч Есүсийн өөдөөс хараатай болохоо бардамнан баримталж, хэнээс ч сургамж авахаас татгалзав. Нүглийг өөрөөсөө түлхдэг бусдад тохоодог тэдний нүглийг “байсаар л байна” гэж Есүс дүгнэсэн (Иохан 9:34, 41). Ертөнцийн Эзэний Үгийг бусдаас илүү нарийн чанд дагадаг мэт дүр үзүүлж байхдаа фарисайчууд хүний тогтоосон ёс заншлыг дагахын тулд Их Эзэний тушаалыг үл ойшоож, орхигдуулж байсан. Гаднаа зөв шударга үзэмжтэй ч, дотроо юутай хуурамч бөгөөд эрээ цээрээгүй бардамнал вэ!



Хуурамч зангаасаа болж фарисайчууд Ертөнцийн Эзэний Үгийг үл тоон басамжилсан бөгөөд энэ зан нь тэднийг мөн адил Ертөнцийн Эзэний махбодтой болсон Үгээс ч татгалзаж, Түүгээр бүр доог тохуу хийхэд хүргэсэн билээ. Тийм ч учраас Есүс дагалдагч нараа мөн **“Паараш бүлгийнхний [=фарисайчуудын] исгэсэн хөрөнгө мэт хуурамч зангаас болгоомжлогтун!”** гэж сануулсан (Лук 12:1, ББ).

“Исгэсэн хөрөнгө” удалгүй гурилыг бүрэн исгэхийн адилаар хоёр нүүрт байдал бидний зүрх сэтгэлд халдан нэг мэдэхэд эзэмшсэн байх аюултай гэж Есүс бидэнд ч гэсэн анхааруулдаг. Энэ бол бодитой сануулга. Фарисайчуудаас ялгаагүй хуурамч зантай итгэгч өнөөдөр олон бий. Тийм хүний хандлага **“Би баян. Баяжсан тул дутах зүйл ер байхгүй”** гэсэн Лаодик сүмийнхнийхтэй ч адил. Харин Есүсийн дүгнэлт бол **“Чи өөрийнхөө хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, ядуу, сохор, нүцгэн байгааг мэдэхгүй байна”** (Илчлэл 3:17)!

Миний амьдралдаа авч үзсэн хамгийн том шокын нэг бол ойр дотны итгэгч хүн бусдын өмнө гарч хүнийг буруутгахын зэрэгцээ **“Би шударга хүн!”** гэж өөрийгөө магтсан явдал юм. Тийм хүн Ертөнцийн Эзэнээс ичиж зовдоггүй юм байх даа?! Өөрийгөө гэмт хүн гэж мэдсэндээ тэнгэр өөд харж ч зүрхлэхгүйтлээ Ертөнцийн Эзэнээс эмээсэн татвар хураагчаас өөрийгөө хамаагүй дээр гэж сайрхсан фарисайгаас тэр итгэгч ямар ялгаатай вэ? Түүнийг Есүс дүгнэхдээ, **“фарисай нь биш, харин [татвар хураагч] зөвтгөгдөн гэртээ харив. Учир нь өөрийгөө**



өргөмжилдөг аливаа хүн номхруулагдаж, өөрийгөө даруу байлгагч нь өргөмжлөгдөнө” гэж хэлсэн (Лук 18:10-14).

Муу ёрын сүнсний зорилго бол үнэн болон шударгыг хайр энэрлээс салгах явдал юм. Гэтэл эдгээр нь Ертөнцийн Эзэний зан чанар ба төлөвлөгөөтэй салшгүй холбоотой билээ (Дуулал 85:10).

Гаднах зан үйлийг заасан ёсоор үйлдэх, Библийг онолын хувьд мэдэн хүлээн зөвшөөрөх гэдэг нь фарисайчууд болон тэдний мөрөөр замнагч христчин хүмүүсийн хувьд зөвт байдал мөн. Гэтэл шашинлаг энэ байдалд нь хайр энэрэл бүхий үнэн зөв шударга үйлс алга.

Фарисайчууд Их Эзэнийх биш, өөрсдийнхөө л зөвт байдлыг тогтоохыг эрмэлздэг гэсэн Паулын дүгнэлт юутай үнэн билээ (Ром 10:3).

Есүс өөрсдийнх нь тухай ярьж байгааг фарисайчууд ойлгосон нь

Чухам ийм хүмүүст Есүс таван хэсэг бүхий мөнөөх сургаалт зүйрлэлээ ярьсан. Харин **“Фарисайчууд ба ахлах тахилч нар Түүний сургаалт зүйрлэлүүдийг**





сонсоод, Тэр өөрсдийнх нь тухай ярьсныг ойлгов” (Матай 21:45).¹

“Урт дээлтэй явах дуртай, зах зээл дээр хүндлүүлэн мэндлүүлэх, синагогт тэргүүн суудалд болоод найран дээр хойморт залрахыг дурлагч” Израйлийн удирдагч нар энэ үлгэрийн баян хүн өөрсдийг нь төлөөлж байгааг ойлгосон нь лавтай (Лук 20:46).



Гарал үүслээрээ сайрхдаг фарисайчууд баян хүнийг Абрахамын үр удам болохыг сонсоод хэн болох нь бүр ч эргэлзээгүй болсон байх (Иохан 8:39; Матай 3:9).

Баян хүн Каиафыг дүрсэлсэн байж магад

Фарисайчууд өнөө баян хүнийг Израйлийн удирдагч хийдэг байсан тэргүүн тахилч Каиаф болохыг ойлгосон ч байж магад. Тухайн үед тэргүүн тахилч

¹ Ахлах тахилч нар фарисай биш, садукай бүлгийн удирдагч билээ (Үйлс 5:17).



иудей ардыг ромчуудын өмнө төлөөлдөг байсан учраас шашны амьдралд төдийгүй, улс төрийн хувьд ч хамгийн нөлөөтэй хүн байсан. Иймээс Каиаф, тахилч нарын өмсдөг маалингийн материалиар хийсэн хувцсаас гадна, томчуудын өмсөх дуртай нил ягаан өнгө бүхий хувцас өмсдөг байсан нь лавтай. Каиафын амьдралын хэв маяг мөнөөх баян хүнийхээс өөрцгүй бөгөөд ордон нь баян хүнийхтэй адил хашааны том хаалгатай (G4440, Матай 26:3,71).

Үүнээс гадна Каиаф өөрөөсөө өмнө тэргүүн тахилч хийсэн Аннасын охинтой сууснаар (Иоган 18:13) таван хүргэн ах дүүтэй болсныг иудей алдарт түүхч Иосеф Флавий² тэмдэглэсэн³. «Талмуд»-ын дагуу Аннасын гэр бүлийнхэн сүмийн өргөөг сахихаас гадна санхүүг нь хариуцдаг бөгөөд сүмд өргөх амьтан зарах, мөнгө солих бизнесийг эрхшээлдээ оруулжээ. Мөнгөнд шунахай тэдний хэт их хөөрүүлсэн үнийг төлөхөөс дургүйцсэн ардыг зарц нар нь таягаар зоддог байсан тухай ч «Талмуд»-ад бичсэн байна. Сүм дээрх худалдааны ачаар асар их баяжсан энэ гэр бүл ромчуудад хээл хахууль өгч хуйвалдснаар олон жилийн турш номер нэг гэр бүл байжээ.

² МЭ 37 онд Иерусалим дахь сүмд үйлчилдэг тахилчийн хүү болж төрсөн Иосеф Флавий фарисай бүлгийн гишүүн байсан бөгөөд Ромын эзэн хааны өргөмөл хүү болж Флавий гэсэн ром нэрийг авсан (Froom, 1966). Түүний бичсэн номнууд өнөөг хүртэл өөрийнх нь үеийн иудейчүүдийн түүх, заншил ба итгэл үнэмшлийн тухай хамгаас дэлгэрэнгүй мэдээлэл агуулдаг билээ. Иосеф Флавий олны дунд сайн түүгч гэдгээрээ танигдсан.

³ Иосеф Флавийгийн тэмдэглэснээр Аннасын таван хүү бүгд хэсэг хугацаанд тэргүүн тахилчаар үйлчилсэн. Аннасын бага хүү Аннас II МЭ 62 онд Есүсийн дүү Иаковыг чулуугаар шидүүлж цаазлах зөвшөөрөл өгчээ.



Гэвч тэдний үйл ажиллагааг Есүс эсэргүүцэж **“Миний гэр бол бүх үндэстний залбирлын гэр гэж нэрлэгдэнэ”** гэж бичигдээгүй гэж үү? **Гэтэл та нар түүнийг дээрэмчдийн үүр болгожээ”** гээд худалдаачдыг нь сүмээс хөөсөн. Үүнийг сонссон ахлагч тахилч нар (буюу Аннасынхан) өөрсдийг нь санхүүгийн хувьд хохироосон Есүсийг хөнөөх арга зам хайж эхэлжээ (Марк 11:15-18).



Ядуу Лазар Март, Марь хоёрын ах буюу уяман яртай Симоныг дүрсэлсэн байж магад

Ядуу Лазар ч фарисайчуудын таньдаг хүн байсан байж магад. Лазар гэдэг нэртэй өөр ганц хүн «Шинэ Гэрээ»-нд гардаг бөгөөд тэрээр Мариа, Марта гэдэг хоёр дүүтэйгээ хамт Бетан тосгонд амьдардаг байв. Бетан гэдэг нь “зовлон зүдүүрийн байр” гэсэн утгатай нэр. Түүний хоёрдахь нэр нь Симон бөгөөд тэрээр нас барж дахин амилуулагдахаасаа өмнө уяман өвчтэй байсан гэсэн үзэл бий.⁴

⁴ Лазар, Симон хоёулаа Бетанд олон хүн орж зооглох боломжтой том байртай байсан. Аль алины гэрт нь нэгэн эмэгтэй их үнэтэй, сав дүүрэн нард хэмээх үнэрт тосоор Есүсийн толгойг тосолсон. Аль ч тохиолдолд дагалдагч нар нь дургүйцээд уг тосыг зарж мөнгийг нь ядуучуудад өгөх ёстой байсан гэхэд Есүс тус бүрдээ тэр эмэгтэйг өмөөрч, Өөрийнх нь оршуулгын бэлтгэл хийж байгааг нь тайлбарладаг. Энэ явдал хоёр удаа тохиолдсон байж болох ч нөхцөл байдал нь дэндүү төстэй учраас нэг л тохиолдол байх магадлал өндөр. Иохан энэ гэрийн эзнийг Лазар гэж нэрлэдэг бол Марк, Матай хоёр түүнийг Симон гэдэг (Иохан 12:1-3; Марк



Өөрөөр хэлбэл, Лазар болон уяман яртай Симон нэг л хүн байсан байх шинжтэй. Арьсны өвчин туссан хүн тахилчдад үзүүлэх хуультай (Левит 13) учраас Есүсийн сонсогчид, нэлээд чинээлэг амьдралтай Симоны өвчний тухай мэдсэн нь лавтай. Тэгвэл тэд Есүсийн өгүүллэгийг сонсохдоо тэр Симон-Лазарыг бодсон байж магад. Өгүүллэг дэх Лазарын бие нь яр шарх дүүрэн байсан нь энэ санааг дэмждэг.

Өвчин тусаад гуйлга хийхээс өөр аргагүйд хүрсэн Лазарыг өрөвдөн хайрлах зүрх сэтгэл фарисайчуудад лав байсангүй. Хамаг баялаг нь үгүй болсон, найзууддаа танигдахааргүй болтол хөлийнх нь улнаас толгойн орой хүртэл яр хатиганд баригдан үнс нурман дээр суусан Иовын түүхээс фарисайчууд юу ч сураагүй шинжтэй (Иов 1-2).



Ертөнцийн Эзэн “дорд нэгнийг тоос шорооноос босгож, Үгээгүй ядууг нь үнс хаягдлаас татдаг”-т итгэдэггүй тэд “зовлон зүдүүрийн байр”-анд буй Лазарыг харин ч Ертөнцийн Эзэний хараал хүртсэн нүгэлтэй амьтан гэж ад үздэг байв (Дуулал 113:7). Ядуу зүдүү, заваан, арчаагүй Лазар

14:3; Матай 26:6). Лук болохоор Симоныг фарисай бүлгийн гишүүн гэж нэмж хэлдэг (Лук 7:36-50). Энэ фарисайн гэрт орж ирсэн гэмт эмэгтэй Лазарын дүү Мариа шиг л Есүсийг үнэт тосоор тослохоос гадна хөлийг нь урт үсээрээ арчдаг. Хэрэв Мариа фарисай Симоны дүү мөн юм бол хэрхэн гэрт нь орж ирсэн байж болох нь ч ойлгомжтой. Энэ бүхнээс харахад фарисай Симон, Лазар хоёр нэг л хүн болох санаа нь үнэмшилтэй.



шиг биш байхдаа фарисайчууд Ертөнцийн Эзэнд талархсан биз ээ (Лук 18:10-14-г үзнэ үү).

Жич хэлэхэд, Есүсийн ярьсан өгүүллэг бодит тэр хоёр хүний тухай байлаа ч гэсэн амьдралд нь болсон явдал байх боломжгүй. Уяман яртай хүн хэзээ ч хүний гэрийн гадаа хэвтэж болохгүй байсан, тийм аймшигт өвчин туссан хүн өвчнөө бусдад халдварлуулахгүйн үүднээс заавал бусдаас хол, хотын гадаа амь зогоох ёстой.⁵

Үүнээс гадна баян хүн Есүсийг өгүүлж байхад аль хэдийнэ нас барсан байх ёстой байхад Каиаф Есүсийг тэнгэрт одсоны дараа ч амьд хэвээр байсан (Үйлс 4:6). Мөн жинхэнэ Лазарыг Есүс үхлээс амилуулсан байхад өгүүллэгийн Лазарыг Абрахам дахин амилуулахаас татгалздаг.

Есүсийн өгүүллэг фарисайчуудыг шүүсэн хэрэг

Гол хоёр дүрээ Есүс танилцуулсны дараахан хоёул нь нас барахад байр нь солигдсон билээ. Энэ нь фарисайчуудыг шоконд оруулахаас өөр аргагүй. Яагаад тэдний талын хүн галд шатаж, харин тэр заваан нүгэлтэй гуйлгачин Абрахамын өвөрт суухаар болсон юм бэ?! Тийм байх ёсгүй! Баян хүмүүс Ертөнцийн Эзэний ивээл буюу сайшаалыг авсан нэгэн ба ядуу, өвчинд баригдсан улсууд хараагдсан гэсэн

⁵ Уяман яртай Симон яагаад бусдаас тусгаарлаагүй харин ч олон хүн урьсан зоог хийж байгаа учрыг тайлах нэг үнэмшилтэй тайлбарын дагуу Симон Есүсээр эдгээгдсэн ч “уяман яртай” гэдэг хоч нэртэй үлдсэн. Тухайн үед олон хүн Симон гэдэг нэртэй байсан учраас тэр.



тэдний ойлголтыг Есүс час зөрчин, орвонгоор нь эргүүллээ. Дээр нь өвөг эцэг Абрахам тэргүүн тахилчийн хүсэлтийн ёсоор болгоогүй, “зөв замыг зааж өгөх Мосе болон эш үзүүлэгч нар сонсог” гэж хэлж түүнийг голохоос гадна Ертөнцийн Эзэний Үгийг сайн мэдэхгүй, сайн дагаагүй гэж доромжилж буй мэт.

Үнэхээр Есүс фарисайчуудыг өөрсдийнх нь үгээр нь шүүж буй хэрэг (Лук 19:22). Хүний үгийг Есүс Их Эзэн ашигладаг байсан хэд хэдэн удаатай. Жишээ нь, фарисайчууд нэг удаа Есүсийг буруутган “Энэ хүн чинь зөвхөн чөтгөрүүдийн захирагч Беелзебулээр ч чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг” гэхэд Есүс хариуд нь “тийм биш” гэх мэтээр маргалдаагүй харин эргээд л тэдний үгээр асуулт тавьдаг (Матай 12:24-27-үзнэ үү). Яг үүнтэй адилаар Есүс баян хүн, ядуу Лазар хоёрын үлгэрт гардаг тэдний уламжлалыг үгүйсгэх ч үгүй, зөвшөөрөх ч үгүй, харин тэднийг шүүх гэж шууд ашигладаг.





Есүс энэ өгүүллэгээр дамжин хүний мөнхийн хувь заяаг харуулахыг зориогүй гэсэн үг. Харин ч үхсэн хойноо ч амьдрах тухай, харийн шашнаас авсан фарисайчуудын ойлголтоор Есүс доог тохуу хийсэн. Ертөнцийн Эзэний үгэнд харш болох энэ буруу ташаа сургаал ямар инээдтэй болохыг Есүс энэ үлгэрээр дамжин тэр Үгийг мэддэг хүн бүрт харуулдаг. Өөрөөр хэлбэл, баян хүн, ядуу Лазарын тухай өгүүллэг бол чадварлаг уран элэглэл буюу цэвэр ёжлолын жишээ.

Фарисайчууд Есүсийг өөрсдийнх нь тухай ярьсан болохыг сайн ойлгосон. “Баян байх нь Ертөнцийн Эзэний сайшаалын баталгаа” гэдэгт итгэж, мөнгөнд шунадаг итгэлийг нь Есүс хуурамч гэснийг тэд ойлгосон биз ээ. Өөрсдийг нь Ертөнцийн Эзэний Үгэнд итгэхгүй, Түүнийг мэдэх ч үгүй гэснийг нь ч ухаарсан байх.

Гэвч фарисайчуудаас далдалсан үнэн энэ сургаалт зүйрлэлд байж таарах учраас гүн утга учир нь тэдэнд оньсого хэвээр үлдсэн гэсэн үг. Бусад сургаалт үлгэрийн адилаар энэ өгүүллэг Их Эзэний Хаант улсын тухай.

Мөнөөх өгүүллэг бол тодорхой хэмжээний зөгнөлийн чанартай. Ертөнцийн Эзэний үгэнд итгээгүй иудейчүүд хэрэв нас барсан хүн эргээд амилсан ч гэсэн үгэнд нь итгэхгүйг Есүс энэ өгүүллэгээр дамжин хэлдэг.

Дараа нь Есүс үнэхээр хүнийг амилуулсан, Өөрөө ч үхлээс амилсан боловч иудейчүүд ихэнхдээ Есүсийн үгэнд итгээгүй. Энэ итгэлгүй байдлыг нь Есүс энэхүү үлгэрээр битүүхнээр зөгнөсөн.



Гайхамшиг хичнээн гайхалтай байлаа ч хүний зүрх сэтгэлийг өөрчилж, өр нимгэн болгон уяраах чадваргүй. Үхмэл шашин хүний сэтгэлийг дэндүү их хатууруулж, оюун ухааныг нь балран харанхуйлдаг учраас нас барсан хүн шашинлаг хүний нүдэн дээр амилсан ч ямар ч өөрчлөлтөнд хүрэхгүй.



Иймд шашинлаг хандлагаас биднийг чөлөөлөөд, үнэнг хайрладаг зөөлөн зүрх сэтгэл өгч, үнэнгээ улам илүү зааж өгөхийг Их Эзэнээс гуйцгаая.

**“Үнэнээр тань алхъя, замаа Та заагаач, ИАВЭ!
Нэрээс тань эмээхэд сэтгэл зүрхийг минь
чиглүүлээч.” (Дуулал 86:11)**

“Айлдвар юуг тань би зүрх сэтгэлдээ хадгалсан...

Таны үгийн гол цөм нь чин үнэн.

Зөвтийн журам ёс тань үүрд мөнх.

Засаг ноёд намайг шалтгаангүй хавчдаг ч

Зүрх сэтгэл минь харин Таны үгээс сүрдэнэ.

Айлдвар үгэнд тань би баяснам.

Асар их олз олсон мэт баяснам.

Худал хуурмагийг үзэн ядаж би жигшинэ.

Хууль зааврыг тань харин нандигнаж хайрлана.

Зөв шударга журам ёсны тань төлөө

Өдөр бүр долоонтаа Таныг магтана.

Хууль зааврыг тань хайрлагсдад их

амар амгалан бий...



Таны авралыг би найдан хүлээдэг, ИАВЭ!”

Дуулал 119:11,160-166



“Библи өөрөө өөрийгөө тайлбарладаг” гэсэн чухал зарчим бий. Дараагийн нийтлэлд бид тэр зарчмын дагуу баян хүн, ядуу Лазар хоёрын тухай сургаалт үлгэрийн утгыг тайлах болно.

Ашигласан эх сурвалж:

- Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.
- Brown, C. (1975). The New International Dictionary of New Testament Theology.
- Bullinger, E. W. (1902). The Rich Man and Lazarus: An Intermediate State? <http://www.biblical-data.org/LAZARUS.pdf> -оос олсон.
- Dawson, S. G. (1943). The rich man, Lazarus, and the afterlife. www.truthaccordingtoscriture.com -оос олсон.
- Eby, J. P. (n.d.). Abraham's bosom: A treatment of the parable of the rich man and Lazarus. <https://godfire.net/eby/abrahams.html> -оос олсон.
- Froom, L. E. (1966). Gravity of Ascribing False Teachings to Christ. www.truthaccordingtoscriture.com -оос олсон.
- Gill, John (1690-1771). Exposition of the Entire Bible. www.biblehub.com хэмээх сайтаас олсон.
- Huie, B. T. (1998). Lazarus and the rich man. www.tentmaker.org -оос олсон.
- Leiter, S.Y. (2003). Grasping the Heel of Esau. www.chabad.org хэмээх сайтаас олсон.
- Martin, E. L. (2003). The real meaning of Lazarus and the rich man. <http://www.what-the-hell-is-hell.com/HellArticles/RichManParable.htm> -оос олсон.



-Smith, L. R. (n.d.). Lazarus and the Rich Man: A scriptural journey through the intriguing

parable of Lazarus and the rich man. www.bible-truths.com -оос олсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

-Patching, J. The rich man and Lazarus.

<http://www.tentmaker.org/books/RichManandLazarus-Patching.html> -оос олсон.

-Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org хэмээх сайтаас олсон.

-Wilson, Larry (2007). The rich man and Lazarus. Wake up America Seminars. www.wake-up.org -оос олсон.

-Witherell, J. F. (1843). Rich man and Lazarus. In *Five Pillars in the temple of partialism removed*. Concord: Balm of Gilead.